



## МОНГОЛЫН СҮСЭГТНИЙ ХОЛБОО

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 16-р хороо,  
Занабазарын гудамж, МБШТөв Гандантэгчэнлин хийд,  
Батцагаан дуган

Утас: 360072

E-mail: mongoliinsusegtniikhholboo@gmail.com

2020.11.25 № 279

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Хуулийн төслийг дэмжих тухай

Эрхэм хүндэт Монгол Улсын Их Хурлын гишүүн Танд энэ өдрийн амар амгаланг айлтган мэндчилье.

Танд “Нөхөн олговор олгох тухай” хуулийн төслийг санаачлан, олон нийтийн саналыг авч хэлэлцүүлж байгаад Бурханы шашинтнууд, сүсэгтэн олны нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Улс төрийн их хэлмэгдүүлэлтэд олон лам хувраг, хутагт хувилгаадыг хилс хэрэгт гүтгэн, алтан амийг нь авч одсон, мэргэд дээдсийн зарлиг сургаал, оюун санааны ховор нандин зохиол бүтээлийг шатаан устгасан, шашин соёлын хосгүй үнэт зүйлс, сүм хийд, өв дурсгалын зүйлсийг нураан сүйтгэсэн зэргээр уламжлалт Бурханы шашин соёлд асар их гарз хохирол учруулсанд монголын ард түмэн бид туйлын их харамсдаг билээ.

Мөн түүнчлэн монголын түүх уламжлал, боловсрол, соёл урлаг зэрэг бүх тогтолцоогоор дамжуулан бурангуй үзэл суртлыг уусган шингээх бодлогыг хэрэгжүүлэхэд асар их хөрөнгө зарсан нь социализмын үед бидний судалсан сурах бичиг, ном зохиол, үзсэн кино, сонирхсон мэдээ мэдээлэл, зохион байгуулж байсан үйл ажиллагаа, хурал цуглаанаар бэлхнээ нотлогддог. Бурангуй үзэл суртлын үр дагаврын илрэл нь ард түмний оюун санааны дархлаа суларсан, уламжлалт шашин соёлоо үр хойчдоо үнэн зөвөөр уламжлуулах зан заншил тасалдсан, ёс суртахуунтай монгол хүний үнэ цэн, ухаалаг, хүнлэг энэрэнгүйн үнэт зүйлс доройтсон одоогийн нийгмээс харагдана.

Иймд Нөхөн олговор олгох тухай хуулийн төсөл батлагдсанаар:

- (1) Уламжлалт шашин соёл үнэн зөвөөр дэлгэрэх хууль эрх зүйн тааатай орчин бүрдэх
- (2) Бурангуй үзэл суртлыг залруулах
- (3) Ард түмэн өв уламжлал, түүх соёлоо үнэн зөвөөр таньж мэдэж, өвлүүлэх оюун санааны эрхээ эдлэх боломж бүрдэх ач холбогдолтой гэж үзэж,

Монголын сүсэгтний холбоо, ижил зорилготой бусад байгууллагууд, гишүүд дэмжигч, сүсэгтэн олон түмэн энэ хуулийн төслийг бүх талаар дэмжиж буйгаа танд үүгээр уламжилж байна.

Таныг хүндэтгэн ёсолсон

ТЭРГҮҮН



Ж.САРАНТУЯА



МОНГОЛ УЛСЫН ХУДАГДАЛ  
ЦАХИМ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

Хэлэлцүүлэг - Төлөөлөл - Тусламж

15 өдөр

### Нөхөн олговор олгох тухай

Байнгын хороогоор төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх	Нэгдсэн хуралдаанаар төслийн үзэл баримтлалыг хэлэлцэх эсэх	Байнгын хорооны анхны хэлэлцүүлэг	Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэг	Байнгын хорооны эцсийн хэлэлцүүлэг	Нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэг
--	---	-----------------------------------	--------------------------------------	------------------------------------	---------------------------------------

Төслийн файлыг татах

Share 0 Tweet

ТӨСЛИЙН ХАВСРАГЧУУД

ТӨСӨЛ САНААЛАГЧИД

дэгсэн (0) үзсэн (18) санал (0)

Нийлэгсэн: Хэлэлцүүлэйн Хөгжч Өмнө 2020-11-23

Та санал өгөхийн түүд нэвтрэх шаардлагагүй!

СЭНЭГ АСУУЛТА

Монгол Улсын Үндсэн зургад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд санааа өгнө үү?

- Дэмжсэнэ 65%
- Дэмжлэггүй 38%
- Мэдээгүй 3%

Санал өгөх

ИРСЭЛИЙН

Монгол Улсын Үндсэн зургад оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл

Экспортын хэвлэйн ерөнхий хэлэлцэвэрийн төсөл саёврон баллах тухай

Төрөөс мөнгөний барлогын газар 2021 онд барилгалах үндсэн чиглэл багтаах тухай УИХ-ын тогтоолын төсөл